



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ
ҮР ДҮНД СУУРИЛСАН МАЯГТ АРГАЧЛАЛЫН
ДАГУУ БОЛОВСРУУЛААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2024/03-22/-НА-НА
АУДИТЫН НЭР: “ХЭНТИЙ АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ
ӨГӨХ”

Чингис хот 2024 он

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Энх-Амгалан, Ц.Билэгсайхан

Аудитор Н.Туяа, Х.Еркегүл, Б.Ариунаа, Б.Хуланхатан,
Т.Алтаншагай

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Тайлан баталгаажуулсан тушаал:	3
Аудит хийх үндэслэл.....	5
Аудитын зорилго	5
Аудитын хамарсан хүрээ.....	5
Аудитын арга зүй	5
Талуудын хүлээх үүрэг хариуцлага.....	5
Хүндрэл бэрхшээл.....	6
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
БҮЛЭГ 1	7
ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ҮР ДҮНД СУУРИЛСАН МАЯГТ АРГАЧЛАЛЫН ДАГУУ БОЛОВСРУУЛААГҮЙ	7
БҮЛЭГ 2	8
ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГЫГ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.	8
2.1. УИХ-аас орон нутгийн төсвийн суурь орлогыг 37,028.1 сая төгрөгөөр баталсныг 3,374.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 293.0 сая төгрөгөөр бууруулан төсвийн төсөлд тусгасан байна.	8
2.2. Төсвийн төсөлд тусгагдсан орлогыг 1,025.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.	10
БҮЛЭГ 3	12
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ, ТӨСВИЙН ЗАРДЛЫН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	12
3.1.Төсвийн төслөөс 2,298.2 сая төгрөгөөр зардлыг бууруулж, 1,199.5 сая төгрөгийн зардлын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.	12
3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн төлөвлөөгүй байна.	16
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 80.2 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 75 хувьтай байна.....	23
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	24
ЗӨВЛӨМЖ:	25
Холбогдох байгууллагын санал:.....	26



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 дугаар сарын 29

Дугаар А/43

Чингис хот

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9 дэх заалт, 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэнтий аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит”-ын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Цогт-Орших), аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь) нарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Цогт-Орших), аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь) нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ахлах аудитор (Г.Энх-Амгалан)-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232410043



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УИХ	Улсын Их Хурлын
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс



Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Хэнтий аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн төслийг Төсвийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх
- Төсвийн орлогыг бодит тооцоо судалгаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
- Төсвийн зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитын явцад аймгийн 2024 оны төсөв, төсвийн тодотгол, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас Сангийн яаманд хүргүүлсэн 2025 оны жилийн төсвийн төсөл, Сангийн Яамнаас хянаж ирүүлсэн тооцоо, холбогдох мэдээлэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ болон ХОХБТХ, БОАЖГ, Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч болон төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, орлого, зардал, төсөвтэй холбоотой тайлан, мэдээ, судалгаа, өмнөх онуудын аудитын тайлан, аймгийн ИТХ-д хүргүүлсэн санал дүгнэлт зэрэгт үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийв.

Аудитын арга зүй

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно. Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалыг гол шалгуур болголоо.

Талуудын хүлээх үүрэг хариуцлага

Аймгийн засаг дарга нь жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Төрийн аудитын байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй. Аймгийн засаг даргаас өргөн мэдүүлсэн Орон нутгийн төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Хүндрэл бэрхшээл

Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг Төсвийн тухай хуульд заасан 5 хоногийн хугацаанд гүйцэтгэдэг байдал нь мэдээллийг бүрэн шинжлэх, иж бүрэн дүгнэлт гаргах аудитын үйл ажиллагаа хязгаарлагддаг. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавьж, УИХ хоригийг хүлээн авах шийдвэрийг гаргасан байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн Засаг даргаас 2024 оны 11 дүгээр сарын 20-нд ирүүлсэн аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргасан болно. Сангийн яамнаас төсөв батлахтай холбоотой чиглэл ирүүлээгүй, төсвийн программ ажиллахгүй, шалгагдагч байгууллагуудаас шаардлагатай мэдээ, судалгаа, тоо баримтыг шаардсан хугацаанд иж бүрэн, үнэн зөв гаргаж ирүүлэхгүй байгаа нь аудит хийж дүгнэлт гаргахад хүндрэл учруулж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн 2024 оны төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж 6,255.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 106,479.1 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр нийт орлого ба тусламжийн дүн 86,436.0 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 73,729.9 сая төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 12,706.1 сая төгрөгийн үр дүнтэй байна.

Орон нутгийн төсвийн орлого 10 дугаар сарын байдлаар 33,835.3 сая төгрөг буюу 119.6 хувийн биелэлттэй, зарлага 80.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар суурь орлогыг 37,028.1 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгт 47,348.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 23,761.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Орон нутгийн төсвийн төсөлд сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 30,610.9 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэгт 13,291.4 сая төгрөгийг тус тус хуваарилж, сумаас аймгийн төсөвт өгөх татаасыг 4,950.1 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны төсвийн төслийн саналд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шилжих 1,828.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 15 төсөл арга хэмжээ, шинээр 9,483.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7,079.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 23 төсөл арга хэмжээ, ОНХС-гийн хөрөнгөөр шилжих 3,237.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 17 төсөл арга хэмжээ, шинээр 12,243.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7,232.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт 1. Төсөл, арга хэмжээний мэдээлэл

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Орон нутгийн төсөв	11	3,428.0	2,000.0
2	Их засвар	22	8,964.4	5,332.4
3	Замын сан	5	2,960.5	1,576.0
4	ОНХСан	36	19,669.8	10,470.0
	Нийт	74	35,022.7	19,378.4



БҮЛЭГ 1

**ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ҮР ДҮНД СУУРИЛСАН МАЯГТ
АРГАЧЛАЛЫН ДАГУУ БОЛОВСРУУЛААГҮЙ**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”-д заасны дагуу Сангийн яамнаас орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон төсвийн хязгаарыг ирүүлсэн байна.

Хэнтий аймгийн төсвийн нийт орлого, зарлагын хязгаарыг 100,538.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс суурь орлого 37,269.1 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 44,078.2 сая төгрөг, суурь зарлага 81,347.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 19,191.1 сая төгрөгөөр тогтоожээ.

Аймгийн Засаг дарга орон нутгийн төсвийн суурь орлогыг 35,158.4 сая төгрөг буюу 2,110.7 сая төгрөгөөр бууруулж, суурь зарлагыг 81,478.3 сая төгрөг буюу 131.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2024 оны 7 дугаар сарын 24-ны өдрийн 9/1431 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Хүснэгт 2. Батлагдсан төсвийн хязгаар

Үзүүлэлт	Төсвийн хязгаар	Хүргүүлсэн санал	Зөрүү
Төсвийн нийт орлогын дүн	100,538.4	100,669.40	
Үүнээс: Суурь орлогын дүн	37,269.1	35,158.40	(2,110.7)
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	44,078.2	46,319.90	2,241.7
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	19,191.1	19,191.1	-
Төсвийн нийт зарлагын дүн	100,538.4	100,669.40	
Үүнээс: Суурь зарлагын дүн	81,347.3	81,478.30	131.0
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	19,191.1	19,191.1	-

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу аймгийн Засаг дарга 2025 оны жилийн төсвийн саналаа 07 дугаар сарын 25-ны өдрийн 9/1430 тоот албан бичгээр аймаг дахь Төрийн аудитын газарт хугацаанд нь ирүүлсэн.

Аймгийн 2025 оны төсвийн төслийг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж болон үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн маягт, зааварчилгааны дагуу бүрэн боловсруулаагүй байна.

Аймгийн Засаг дарга нь 2025 оны жилийн төсвийн саналаа shilendans.gov.mn системд байршуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны 9/1988 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан шаардлагад бүрэн нийцээгүй байна. Тухайлбал:

- ✓ санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээ, хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлоогүй,
- ✓ хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх
- ✓ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх



- ✓ эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх
- ✓ эрхлэх асуудлын хүрээнд төсвөөс санхүүжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх
- ✓ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргаж ирүүлээгүй байна.

Иймд төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, холбогдох баримт материалыг хуульд заасан хугацаанд бүрэн ирүүлэхийг анхаарах шаардлагатай байна


БҮЛЭГ 2

ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГЫГ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

2.1. УИХ-аас орон нутгийн төсвийн суурь орлогыг 37,028.1 сая төгрөгөөр баталсныг 3,374.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 293.0 сая төгрөгөөр бууруулан төсвийн төсөлд тусгасан байна.

УИХ-аас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан 2025 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 47,384.3 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 23,761.1 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогыг 37,028.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад санхүүгийн дэмжлэг 8,570.7 сая төгрөг буюу 22.1 хувиар, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 5,174.0 сая төгрөг буюу 27.8 хувиар, орон нутгийн төсвийн орлого 2,158.4 сая төгрөг буюу 6.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

График 1. Орон нутгийн төсвийн орлого, санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн өсөлт



УИХ-аас орон нутгийн төсвийн орлогыг 37,028.1 сая төгрөгөөр баталсныг аймгийн Засаг дарга 5 нэр төрлийн орлогыг 3,374.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 3 нэр төрлийн орлогыг 293.0 сая төгрөгөөр бууруулан 40,109.7 сая төгрөгөөр төлөвлөж ирүүлсэн байна. Үүнд:

Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 2,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 22,800.0 сая төгрөг



Хөрөнгийн орлогыг 220.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,500.0 сая төгрөг
Хөрөнгө борлуулсны орлогыг 27.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 377.6 сая төгрөг
Ус, рашаан нөөц ашигласны төлбөрийн орлогыг 312.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,419.0 сая төгрөг
Төсвийн байгууллагын өөрийн орлогыг 15.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 54.5 сая төгрөг
Үл хөдлөх хөрөнгийн татварыг 90.0 сая төгрөгөөр бууруулж, 900.0 сая төгрөг
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг 58.0 сая төгрөгөөр бууруулж, 750.0 сая төгрөг
Газрын төлбөрийг 145.0 сая төгрөгөөр бууруулж, 1,195.0 сая төгрөг байхаар тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсвийн орлогын төлөвлөлтийн өөрчлөлт

№	Орлогын нэр төрөл	Сангийн яам хянасан	Төсвийн орлогын санал	Зөрүү /+хасагдсан, -нэмэгдсэн/
1	Татварын орлого	34,205.8	37,272.4	(3,066.6)
2	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	20,000.0	22,800.0	(2,800.0)
3	Үйл ажиллагааны орлого	600.0	600.0	-
4	Хөрөнгийн орлого	1,280.0	1,500.0	(220.0)
5	Хөрөнгө борлуулсны орлого	350.0	377.6	(27.6)
6	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,300.0)	(1,300.0)	-
7	Аж ахуй нэгжийн албан татвар	6,600.0	6,600.0	-
8	Үл хөдлөх хөрөнгийн татвар	990.0	900.0	90.0
9	Бууны албан татвар	37.0	37.0	-
10	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	808.0	750.0	58.0
11	Малын тоо толгойн албан татвар	-	-	-
12	Улсын тэмдэгтийн хураамж	200.0	200.0	-
13	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65.0	65.0	-
14	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	791.4	791.4	-
15	Газрын төлбөр	1,340.0	1,195.0	145.0
16	Газрын дуудлага худалдаа	610.0	610.0	-
17	Ойн нөөц ашигласны төлбөр	283.8	283.8	-
18	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	443.6	443.6	-
19	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,107.0	1,419.0	(312.0)
20	Татварын бус орлого	2,822.3	2,837.3	(15.0)
21	Торгуулийн орлого	1,682.8	1,682.8	-
22	Төсвийн байгууллагын өөрийн орлого	39.5	54.5	(15.0)
23	Бусад орлого	900.0	900.0	-
24	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	200.0	200.0	-
	НИЙТ ДҮН	37,028.1	40,109.7	(3,081.6)

Аймгийн орон нутгийн төсвийн төслийн орлогын төлөвлөгөөнд Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 22,800.0 сая төгрөгөөр төлөвлөснийг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад 5,697.2 сая төгрөг буюу 25 хувиар нэмэгдүүлсэн



байна. Энэ нь Төрийн албан хаагчдын цалин, хөлсийг 2025 онд инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувь нэмэгдүүлэх, улсын төсвийн байгууллагын албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгохтой холбоотой байна.

Орон нутгийн төсвийн төсөлд малын тоо толгойн албан татвар, сангуудын зээлийн эргэн төлөлт, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл зэргийг тусгаж төлөвлөөгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

2.2. Төсвийн төсөлд тусгагдсан орлогыг 1,025.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар 2025 оны төсвийн төсөлд тусгагдсан орлогоос дараах нэр төрлийн орлогын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийлээ.

1.Үл хөдлөх хөрөнгийн татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар

Үл хөдлөх хөрөнгийн татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын орлогын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилийн судалгаанаас харахад 150-с дээш хувиар давж биелсэн байна

Хүснэгт 4. Үл хөдлөх хөрөнгийн татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын биелэлт /сүүлийн 3 жилээр/

№	Орлогын төрөл	2022 он			2023 он			2024 он				
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+тасарсан, - давсан/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+тасарсан, - давсан/	Төлөвлөгөө	10 сарын гүйцэтгэл	11, 12 сарын ХБГ	Гүйцэтгэл	Зөрүү /+тасарсан, - давсан/
1	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	463.0	645.1	(182.1)	470.0	692.8	(222.8)	620.0	720.4	5.8	726.2	(106.2)
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	464.0	614.8	(150.8)	620.5	809.6	(189.1)	692.4	676.8	157.5	834.3	(141.9)
	ДҮН	927.0	1,259.9	(332.9)	1,090.5	1,502.4	(411.9)	1,312.4	1,397.2	163.3	1,560.5	(248.1)

Иймээс дээрх орлогуудыг Сангийн яамны хянаснаас бууруулсан нь үндэслэлгүй байгаа байна.

Иймд үл хөдлөх хөрөнгийн татварыг 90.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 990.0 сая төгрөг, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг 58.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 808.0 сая төгрөг нийт 148.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.



2.Газрын төлбөр

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө өмнөх онуудад жил бүр давж биелсэн, өмнөх оны авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 5. Газрын төлбөрийн төлөвлөлт


№	Сумын нэр	2022 он			2023 он			2024 он			Ирүүлсэн санал	Нэмэгдүүлэх санал	Нийт батлах дүн		
		Ногдсон	Төлөв	Гүйцэтгэл	Ногдсон	Төлөв	Гүйцэтгэл	Ногдсон	Төлөвлөсөн	10 сарын гүйцэтгэл				11, 12 сарын ХБГ	Нийт ХБГ
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12=10+11	13	14=9-13	
1	Газрын төлбөр	1,139.8	782.5	845.1	1,362.5	973.5	1,073.4	1,496.0	1,330.0	871.8	392.8	1,264.6	1,195.0	50.0	1,245.0
	ДҮН	1,139.8	782.5	845.1	1,362.5	973.5	1,073.4	1,496.0	1,330.0	871.8	392.8	1,264.6	1,195.0	50.0	1,245.0

Газрын төлбөрийн орлогын төлөвлөлтийг сум тус бүрээр ногдуулалттай тулгахад зарим сумд дутуу төлөвлөсөн тул 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.

3.Сумаас аймгийн төсөвт өгөх татаас

Аймгийн төсөвт Бор-Өндөр, Хэрлэн сумаас авах татаасыг жил бүр нэмэгдүүлэн баталж, төвлөрүүлдэг боловч тус сумдын төсвийн орлого 2022, 2023 онуудад 106-120 хувийн биелэлттэй байгаа нь татаасыг дутуу төлөвлөснийг харуулж байна.

График 2. Сумаас аймагт өгөх татаас, давсан орлогын харьцаа



Дээрх сумдын орон нутгийн төсвийн орлого 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр Бор-Өндөр сумын татварын орлого 447.2 сая төгрөг, Хэрлэн сумын татварын орлого 1,944.2 сая төгрөгөөр давж биелэхээр байгаа тул татаасыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1-д “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн ... 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.” гэсэн заалтыг үндэслэн давсан орлогын 30 хувь буюу 717.4 сая төгрөгийг дээрх 2 сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх саналтай байна.

4.Орон нутгийн хөгжлийн сангийн орлого

Төсвийн тухай хуульд орсон 2022 оны өөрчлөлтөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн орлогыг тус санд төвлөрүүлж зарцуулахаар зохицуулалтын хүрээнд төсвийн төсөлд эх үүсвэрийг нэмэгдүүлж төлөвлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.⁹, 60.2.9.¹⁰ дахь заалттай нийцэхгүй байна. Орлогын төлөвлөлт бүрдүүлэлттэй холбоотой дээрх нөхцөл байдлаас харахад сангийн орлогыг хуульд заасан нэр төрөл тус бүрээр /ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээс бусад/ тооцоолж төлөвлөх, биелэлтийг хангах, сангийн орлогыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.



Аймгийн Засаг дарга тусгай зөвшөөрөл бүхий 18 аж ахуйн нэгжтэй 2022 оноос гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээг үндэслэн ОНХСангийн эх үүсвэрийг 110.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.

Малын тоо толгойн албан татвар:

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд малын тоо толгойн албан татварыг тооцож төлөвлөөгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын хувьд 2023 онд 1,460.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,199.7 сая төгрөгийн орлого төвлөрч биелэлт 82.2 хувьтай байсан бол 2024 онд 721.1 сая төгрөгөөр баталж, 10 дугаар сарын байдлаар 427.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 497.8 сая төгрөг буюу 116.4 хувийн биелэлттэй, 615.8 сая төгрөгийн малын албан татварыг төлөөгүй үлдэгдэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны өвөл цас их орж, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор 11 сумд тухайн татварыг 0 болгон чөлөөлсөн байна.

Иймээс Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоож, төлөвлөн баталж, төвлөрүүлж ажиллах нь зүйтэй.

БҮЛЭГ 3

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ, ТӨСВИЙН ЗАРДЛЫН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1.Төсвийн төслөөс 2,298.2 сая төгрөгөөр зардлыг бууруулж, 1,199.5 сая төгрөгийн зардлын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.2²-т заасан хугацаанд орон нутгийн төсөвт байгууллагуудын 2025 оны төсвийн төслийг холбогдох маягтын дагуу хүлээн авч хянан Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу нэмэлт тооцооллуудыг хийж, төсвийн урсгал зардлыг төсөв захирагч бүрээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн зарлагыг УИХ-аас 108,137.5 сая төгрөгөөр баталсныг аймгийн Засаг даргаас 3,081.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 111,219.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Үүнээс аймгийн төсвийн зарлагыг авч үзвэл 5,210.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 85,712.3 сая төгрөгөөр төсөвлөн аймгийн ИТХ-д өргөн барихаар боловсруулсан байна.

Нэмэгдүүлсэн зарим зарлагыг авч үзвэл орон нутгийн хөрөнгө оруулалтыг 2,000.0 сая төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 2,630.0 сая төгрөг, урт хугацаат зээлийн хүүг 517.1 сая төгрөг, хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг 280.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлагын 72 хувийг урсгал зардал, 28 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна. Зардлын эдийн засгийн ангиллаар авч үзвэл:




График 3. 2025 оны зарлага эдийн засгийн ангиллаар



Нийт зардалд эзлэх зардлын ангиллыг авч үзвэл цалингийн зардал 25 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 25 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 12 хувь, хөрөнгийн зардал 28 хувь, бусад зардлууд 10 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг 2024 оны батлагдсан төсөвтэй харьцуулж үзвэл нийт зардал 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг зардлын ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

График 4. Төсвийн зарлага /2024оны батлагдсан төсөв, 2025 оны төсөл/




Дээрх графикаас үзвэл өмнөх оноос цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал өссөн бол, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг, хангамж бараа материалын зардлууд буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагыг өмнөх онуудтай харьцуулж үзвэл төсвийн зарлага дунджаар 20 хувийн өсөлттэй байна.



График 5. Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл /2022-2025/



Зардал бууруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар дараах саналыг оруулж байна:

1.Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд Аймгийн ИТХ-ын 35 төлөөлөгчийн үйл ажиллагааны зардалд 280.0 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам” -д заасан зардлын нийтлэг жишигтэй нийцэхгүй байна.

Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг журамд заасан нийтлэг жишгийн дагуу тооцоолоход 175.0 сая төгрөг болж байна. Иймд уг зардлыг 105.0 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.

2.Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд аймгийн ЗДТГ-ын цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ын зардалд нийт 3,270.7 сая төгрөг, орон тоог 80 байхаар төлөвлөсөн байна. Үүнд аймгийн Засаг даргын орон тооны зөвлөх ажиллуулахаар 63.6 сая төгрөг төсөвлөсөн нь Монгол улсын “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл. 5.4-т “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ын зардлаас Засаг даргын орон тооны зөвлөхийн албан тушаалд олгохоор төлөвлөсөн 63.6 сая төгрөгийг бууруулах саналтай байна.

3.Түлш, халаалтын зардал

Орон нутгийн төсвийн төсөлд 2025 оны халаалтын зардлыг УИХ-аас баталснаас 248.6 сая төгрөгөөр бууруулж 21,901.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын тушаал, эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон үнэ тариф, барилгын талбайн эзлэхүүн, тус онд нэмэгдэх хувь хэмжээгээр нь тооцож үзэхэд Орон нутгийн судлах музейд 46.4 сая төгрөг, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 12.8 сая төгрөг, Галшар сумын ЭМТ-д 18.4 сая төгрөг, Галшар сумын Соёлын төвд 11.5 сая төгрөг, Галшар сумын ЗДТГ-т 44.7 сая төгрөг, Цэнхэрмандал сумын ЗДТГ-т 7.8 сая төгрөг, Хэрлэн сумын ЗДТГ-т 11.8 сая төгрөгөөр тус тус илүү төлөвлөсөн байна.

Иймд халаалтын зардлыг нийт 153.5 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.



4.Эрсдэлийн сан

Эрсдэлийн санд 2025 онд 600.0 сая төгрөг төсөвлөсөн байна. Энэ нь Гамшгийн тухай хуулийн 51.2-д “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна.” гэснийг баримтлаагүй байна.

Иймд эрсдэлийн сангийн зардлыг 257.1 сая төгрөгийг нэмж төлөвлөх шаардлагатай байна.

5.Мал аж ахуйг хөгжүүлэх зардал

Мал аж ахуйг хөгжүүлэх зардлыг УИХ-аас 881.3 сая төгрөгөөр баталсныг орон нутгаас нэмэгдүүлээгүй байна. “Алсын хараа 2050”, Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн бүсчилсэн хөгжилд тусгасан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, үйлдвэр технологийн парк байгуулан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох зорилтын хүрээнд 10 жилийн хугацаанд орон нутгийн бүх малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулахад санхүүжилтийг жил бүр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Иймд уг зардлыг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал оруулж байна.

6.Хүүхэд хамгааллын зардал

Орон нутгаас хүүхэд хамгааллын чиглэлээр тусгайлан төсөв төлөвлөөгүй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39.1.2-д “тухайн шатны жилийн төсвийн төсөлд хүүхэд хамгааллын санхүүжилтийг тусгах;”, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19.1.5-д “тухайн шатны жилийн төсвийн төсөлд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд 50.0 сая төгрөгийн зардлыг нэмж төлөвлөх санал оруулж байна.

7.Засаг даргын үйл ажиллагааны зардал

Хэнтий аймгийн 2025 оны төсвийн төсөлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 70 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,630.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Дээрх хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнээс 1,514.0 сая төгрөгийн 45 арга хэмжээ нь аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн 01 тогтоолоор баталсан аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан, 1,116.0 сая төгрөгийн 25 арга хэмжээ нь төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч алсын хараа 2050, МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаж байгаа боловч хөтөлбөрийн зардалд тусгасан төсөл арга хэмжээнүүд нь цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, зөвхөн тухайн жилд хэрэгжих эсэх нь тодорхойгүй, суурь болон хүрэх түвшний үзүүлэлт, чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт тодорхой бус байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.4-т зааснаар аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах хуулийн хугацаа болоогүй байна. Иймд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн



төслийг дээрх хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2, 6.10.4 дэх заалтуудын шалгуурыг хангасан болон бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй тул хөтөлбөрийн хэрэгжилтийг 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх аудитын хүрээнд авч үзнэ.

Иймд хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2, 6.10.4-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.1, 7.2-т заасныг хэрэжүүлэх нь зүйтэй байна.

8.Бусад зардал:

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас Цэнхэрмандал сумын нутагт хөв цөөрөм сэргээх засварлах арга хэмжээнд 180.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь зураг төсөвгүй, шаардагдах хөрөнгийн тооцоо судалгаагүй бөгөөд тус газарт 2020 онд 98.6 сая төгрөгөөр хөв цөөрөм байгуулж байсан байна. Биндэр сумын төвийн үерийн усны аюулаас сэргийлэх инженерийн байгууламжийн зураг төсөвт 35.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь тооцоо судалгаагүй, ямар үндэслэлээр тусгасан нь тодорхойгүй байна

Хэрлэн 1-р сургуулийн хүчилтгэлтэй холбоотойгоор шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр 52.4 сая төгрөгийг төсвийн төсөлд нэмж тусгасан нь төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй.

Бэрх Хот тохижилтод 340.0 сая төгрөгийг хуваарилсан нь ямар чиг үүргийг гүйцэтгүүлэх нь тодорхой бус, алдагдлыг санхүүжүүлэх татаас хэлбэрээр олгож байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Иймд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг 215.0 сая төгрөгөөр бууруулж, 392.4 сая төгрөгийн зардлын үр ашгийг дээшлүүлэх санал оруулж байна.

3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засвар, автозамын сан, ОНХС-ийн хөрөнгөөр нийт 35.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 19,378.4 сая төгрөгөөр санхүүжүүлэх 74 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Хүснэгт 7. Хөрөнгө оруулалтын төрлөөр

сая.төгрөг

Д/д	Төрөл	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Орон нутгийн төсөв	11	3,428.0	2,000.0
2	Их засвар	22	8,964.4	5,332.4
3	Замын сан	5	2,960.5	1,576.0
4	Орон нутгийн хөгжлийн сан	36	19,669.8	10,470.0
	ДҮН	74	35,022.7	19,378.4

Мөн 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг хэрэгжих хугацаагаар нь задалж харвал өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 13,296.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5,066.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 төсөл, арга хэмжээ байна.



Хүснэгт 8. Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа

сая.төгрөг

Д/д	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо		Төсөвт өртөг		2025 онд санхүүжих дүн	
		Шинэ	Шилжих	Шинэ	Шилжих	Шинэ	Шилжих
1	Орон нутгийн төсөв	8	3	2,470.0	958.0	1,312.0	688.0
2	Их засвар	14	8	5,919.0	3,045.4	4,673.6	658.8
3	Замын сан	1	4	1,094.2	1,866.3	1,094.2	481.8
4	Орон нутгийн хөгжлийн сан	19	17	12,243.4	7,426.4	7,232.4	3,237.6
		42	32	21,726.6	13,296.1	14,312.2	5,066.2

Шинээр 21,726.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 14,312.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 42 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс төсөл, арга хэмжээний ангиллаар харьцуулж үзвэл 45.2 хувийг барилга, байгууламж, 35.7 хувийг их засвар, 14.3 хувийг тоног төхөөрөмж, 4.8 хувийг зураг төслийн ажил эзэлж байна.

Хүснэгт 9. Шинэ хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

сая.төгрөг

Д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Барилга, байгууламж	19	12,759.6	7,523.6
2	Их засвар	15	6,469.0	4,948.6
3	Тоног төхөөрөмж	6	1,470.0	812.0
4	Зураг төсөл	2	1,028.0	1,028.0
	Нийт	42	21,726.6	14,312.2

Төсвийн төсөлд өмнөх оноос шилжсэн 32, шинээр хэрэгжих 42 төсөл арга хэмжээ тусгаснаас шинээр хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй 8, аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй 18 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 6. Хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл арга, хэмжээ

№	Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг	Төсөвт өртөг /сая төг/	Санхүүжүүлэх дүн /сая төг/	Уялдаагүй төсөл, арга хэмжээний тоо	Давхардсан тоо
1	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	3,032.3	2,252.27	8	7
2	Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	8,642.34	5,792.74	18	

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-д “орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” заалтад нийцүүлэн төсвийн төлөвлөлтийг боловсруулах шаардлагатай байна.

Төсвийн төсөлд Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй огт зураг



төсөл, төсөвгүй 6 төсөл, арга хэмжээ, зураг төсөл, төсөвтэй 28 төсөл, арга хэмжээг тусган ирүүлжээ.

Хүснэгт 10. ТАХ-ний төлөвлөлтийн шаардлагын нийцэл

сая.төгрөг

д/д	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ	Зураг төсөвтэй	Үүнээс		Зураг төсөвгүй
				Магадлалаар баталгаажсан	Хугацаа дууссан магадлалтай	
1	Орон нутгийн төсөв	2	1			1
2	Их засвар	14	12	4	2	2
3	Замын сан	1	-	-	-	1
4	Орон нутгийн хөгжлийн сан	17	15	7	2	2
ДҮН		34	28	10	4	6

Зураг төсөл, төсөвтэй барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29¹.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т заасны дагуу сүүлийн 2 жилийн хугацаанд хийсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвтэй байх шаардлагад нийцсэн 6,407.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 3,721.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ байна.

Мөн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөвтэй төсөл, арга хэмжээнээс 1,933.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэж заасан шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 11. Магадлалын хугацаа дууссан төсөл, арга хэмжээ

сая.төгрөг

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Авто замын гэрэлтүүлэг ажлын үргэлжлэл /Батноров сум, Бэрх тосгон/	ОНХС	Барилга байгууламж	2025	2025	162.2	162.2
2	"Эзэнт гүрэн мини парк"-ын хэсэгчилсэн гадна тохижилтын ажил	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	1,000.0	500.0
3	"280 хүүхдийн цэцэрлэг"-ийн барилгын халаалт агаар сэлгэлт, холбоо дохиоллын засварын ажил /Батноров сум, Бэрх тосгон/	ИЗ	Их засвар	2025	2025	478.4	334.9
4	Захирагчийн ажлын албаны их засварын үргэлжлэл /Хэрлэн сум, Өлзийт тосгон/	ИЗ	Их засвар	2025	2025	292.6	292.6
						1,933.2	1,289.7



Зураг төсөл, төсөвтэй боловч магадлалын ерөнхий дүгнэлт гарч баталгаажуагүй 17 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 10 төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсвийг Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн боловч аймгийн 2025 оны төсвийн төслийг ирүүлэх хугацаанд магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргаж ирүүлээгүй байна.

Хүснэгт 12. Магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй төсөл, арга хэмжээ

сая.төгрөг

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Аймгийн ЗДТГ-ын дээвэр, ИШС-ний засвар, граж барих	ОНХО	Их засвар	2025	2026	550.0	275.0
2	Сумдын төрийн байгууллагыг ИШС-нд холбох ажил /Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Цэнхэрмандал/	ОНХС	Барилга байгууламж	2025	2025	880.1	880.1
3	Шинэ суурьшлийн бүсийн 0.4кв-ын цахилгаан дамжуулах шугамын өргөтгөлийн ажил /Дадал/	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	390.0	195.0
4	Дуурлиг баг буюу сумын төвийн гудамж эгнээн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Баян-Адарга сум/	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	200.0	100.0
5	Шинэ Өндөрхаан хорооллын тохижилт, тоглоомын талбай	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	363.1	181.6
6	ТОСК-ийн байрны гадна тохижилт, тоглоомын талбай	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	500.0	292.0
7	"Хэнтий политехник коллежийн барилгын, дулаалга, фасад засвар /Хэрлэн сум, 4-р баг/	ИЗ	Их засвар	2025	2025	450.0	275.0
8	Хэрлэн 4-р цэцэрлэгийн их засварын ажил	ИЗ	Их засвар	2025	2026	410.0	287.0
9	Сургуулийн их засвар /Өмнөдэлгэр/	ИЗ	Их засвар	2025	2026	478.2	431.0
10	Ахмадын сувиллын барилгын засвар, ИШС-ний ажил /Хэрлэн сум/	ИЗ	Их засвар	2025	2026	397.6	198.8
НИЙТ						4,619.0	3,115.5

Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд заасан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй, батлагдсан зураг төсөвгүй 2,111.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,761.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл арга хэмжээг хасах шаардлагатай байна.

Хүснэгт 13. Зураг төсөл, төсөвгүй төсөл, арга хэмжээ

сая.төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Нийтийн тээврийн үйлчилгээний газрын барилга, гадна зогсоол /Жаргалтхаан сум/	ОНХО	Барилга байгууламж	2025	2026	450.0	225.0
2	Спорт заалны гадна тохижилт /Баянмөнх сум/	ОНХС	Барилга байгууламж	2025	2025	250.0	125.0
3	Шинэ суурьшлын бүсэд 0.4кв цахилгаан хангамж татах ажил /Батноров сум/	ОНХС	Барилга байгууламж	2025	2025	67.0	67.0



4	ЕБС-ийн дотуур байрны барилгын их засвар Галшар/	ИЗ	Их засвар	2025	2025	150.0	150.0
5	ЕБС-ийн дээврийн засвар /Батширээт/	ИЗ	Их засвар	2025	2025	100.0	100.0
6	Авто замын засвар, шинэчлэлт /Хэрлэн сум/	ЗС	Барилга байгууламж	2025	2025	1,094.2	1,094.2
НИЙТ ДҮН						2,111.2	1,761.2

Төсвийн төсөлд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,028.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй зураг төслийн 2, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,470.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 812.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй тоног төхөөрөмжийн 6 ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 14. Зураг төсөл, тоног төхөөрөмжийн ангиллын төсөл, арга хэмжээ

сая.төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Тоног төхөөрөмж	6	1,470.0	812.0
2	Зураг төсөл	2	1,028.0	1,028.0
Нийт		42	2,498.0	1,840.0

Зураг төслийн ангиллын 2 төсөл, арга хэмжээ нь зургийн даалгаврыг боловсруулан батлуулсан бол тоног төхөөрөмжийн ангиллын 1 төсөл, арга хэмжээ /Эмнэлгийн тоног төхөөрөмж/ техникийн тодорхойлолтыг боловсруулан ирүүлсэн байна.

Харин Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 3.1.4.5-д заасан шаардлагыг хангаагүй 1,280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ байгааг анхаарч цаашид зөрчлийг давтан гаргахгүй, шаардлага хангасан арга хэмжээг төсөлд тусгаж байх.

Хүснэгт 15. Техникийн тодорхойлолт байхгүй төсөл, арга хэмжээ

сая.төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүж их дүн
1	Иргэдэд үйлчлэх ХУРДАН төвийн нарны толь суулгах, цахилгаан машин цэнэглэгч суурилуулах ажил	ОНХО	Тоног төхөөрөмж	2025	2026	450.0	250.0
2	Сумдын эрүүл мэндийн төвийн машин	ОНХО	Тоног төхөөрөмж	2025	2025	100.0	100.0
3	Сумдын ЗДТГ авто машин	ОНХО	Тоног төхөөрөмж	2025	2025	280.0	140.0
4	Хот тохижилтын тоног төхөөрөмж	ОНХО	Тоног төхөөрөмж	2025	2026	350.0	175.0
5	Орон нутаг сурталчлах танхимын барилга, музей үзвэр /Цэнхэрмандал/	ОНХО	Тоног төхөөрөмж	2025	2026	100.0	50.0
Нийт						1,280.0	715.0

Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хүрээнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19,669.8 сая төгрөгийн төсөвт өртөг, 10,470.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.



Үүнээс барилга байгууламж 29, их засвар 4, зураг төслийн ангиллын 3 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 16. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ сая.төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Барилга, байгууламж	29	16,192.3	8,384.4
2	Их засвар	4	2,419.5	1,042.6
3	Зураг төсөл	3	1,058.0	1,043.0
Нийт		36	19,669.8	10,470.0

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т заасан чиг үүрэгт 36 төсөл, арга хэмжээ нийцэж байна.

Хүснэгт 17. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиг үүрэг

д/д	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний чиг үүрэг	Төсөл, арга хэмжээний тоо
1	4.2.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи	5
2	4.2.2. Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	11
3	4.2.3. Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	17
4	4.2.5. Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах	3
Нийт		36

Харин аймгийн ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөхдөө Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ын журам”-ын 4.1.2-т “Сум, дүүргийн иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх” үндсэн нөхцөлийг хангаагүй 409.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг сумын ОНХС-аар хэрэгжүүлэх боломжтой боловч аймгийн ОНХС-д тусгасан нь батлагдсан тушаал шийдвэрийг мөрдөхгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 19. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээ сая.төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Балдан врайбүн хийдийн их засвар, гадна тохижилт /Өмнөдэлгэр/	2025	2026	180.1	90.1
2	Шинэ суурьшлын бүсэд 0.4кв цахилгаан хангамж татах ажил /Батноров сум/	2025	2025	67.0	67.0
3	Авто замын гэрэлтүүлэг ажлын үргэлжлэл /Батноров сум, Бэрх тосгон/	2025	2025	162.2	162.2
				409.3	319.3

Сумын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй төсөл, арга хэмжээний саналыг авч жагсаалт гаргасан, ажлын хэсэг нь олон нийтэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн, урьдчилсан жагсаалтыг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн эсэх талаар нотлох баримтыг аудит хийх хугацаанд ирүүлээгүй тул цаашид анхаарах нь зүйтэй байна.

Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон



нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дахь заалтыг баримталж, сумдын ОНХС-аар хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг тусгахгүй байх нь зүйтэй.

Хэнтий аймгийн 2025 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр 42 төсөл, арга хэмжээ тусгаснаас 6 төсөл, арга хэмжээний ашиглалттай холбоотой урсгал зардлыг бүрэн тооцоогүй бөгөөд 2 төсөл арга хэмжээ нь 2025 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4.4 дэх хэсэгт тусгасан төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэхтэй нийцэхгүй байна. Эдгээр 2 төсөл, арга хэмжээний ашиглалттай холбоотой урсгал зардлыг 2025 оны төсвийн төсөлд тусгах шаардлагатай байна.

Хүснэгт 19. Урсгал зардал тооцоогүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Нийтийн тээврийн үйлчилгээний газрын барилга, гадна зогсоол /Жаргалтхаан сум/	ОНХО	Барилга байгууламж	2025	2026	450.0	225.0
2	Орон нутаг сурталчлах танхимын барилга, музей үзвэр /Цэнхэрмандал/	ОНХО	Тоног төхөөрөмж	2025	2026	100.0	50.0
3	Авто замын гэрэлтүүлэг ажлын үргэлжлэл /Батноров сум, Бэрх тосгон/	ОНХС	Барилга байгууламж	2025	2025	162.2	162.2
4	Сумдын төрийн байгууллагыг ИШС-нд холбох ажил /Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Цэнхэрмандал/	ОНХС	Барилга байгууламж	2025	2025	880.1	880.1
5	Дуурлиг баг буюу сумын төвийн гудамж эгнээн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Баян-Адарга сум/	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	200.0	100.0
6	Гэр хорооллын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Хэрлэн/	ОНХС	Барилга байгууламж	2025	2026	500.0	250.0
Нийт						2,292.3	1,667.3



Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 80.2 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 75 хувьтай байна.

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 3,235.8 сая төгрөг, зардал бууруулах 1,418.7 сая төгрөг, төсвийн үр ашгийг сайжруулах 4,061.4 сая төгрөгийн санал дүгнэлт гаргаж, цаашид анхаарах асуудлын талаар аймгийн ИТХ-ын даргад 3, аймгийн Засаг даргад 7 зөвлөмж хүргүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг аймгийн ИТХ-ын 2024 оны 6 дугаар сарын 21-ний 141 дүгээр дугаар албан бичгээр, аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг аймгийн ЗДТГ-ын 2024 оны 6 дугаар сарын 17-ны 3/1225 дугаар албан бичгээр тус тус ирүүлснийг үнэлэхэд хэрэгжилт 80.2 хувьтай байна. Үүнд:

- Аймгийн 2024 оны төсвийн төсөлд 3,235.8 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэхээр хүргүүлсэн саналаас 1,381.1 сая төгрөгийн орлогыг төсөвт тусган баталж хэрэгжилт 69.1 хувьтай байна. АТБӨЯХ-ийн албан татварын орлого, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутгасан албан татварын орлого, газрын төлбөрийн орлого, бусад орлогыг нэмэгдүүлэхээр өгсөн саналыг бүрэн тусгаж, Малын тоо толгойн албан татварын орлогыг 45.5 хувиар тусгажээ.
- Урсгал зардлыг бууруулах 173.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг хасах саналыг бүрэн хэрэгжүүлж, үр ашиг дээшлүүлэх 3 саналыг 66.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санал дүгнэлт өгөх аудитаар аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэд 2 албан шаардлага хүргүүлснээс 191.3 сая төгрөгийн зөрчлийг залруулах албан шаардлагын хэрэгжилт 50 хувьтай, 4,060.7 сая төгрөгийн зөрчлийн арилгах албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн 2025 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.4 -д заасан шаардлагыг хангаагүй байна.
2. УИХ-аас орон нутгийн төсвийн суурь орлогыг 37,028.1 сая төгрөгөөр баталсныг 3,374.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 293.0 сая төгрөгөөр бууруулан 40,409.7 сая төгрөг байхаар төсвийн төсөлд тусгасан байна.
3. Төсвийн төсөлд малын тоо толгойн албан татвар, сангуудын зээлийн эргэн төлөлт, зээл олголт, орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлийг тооцож тусгаагүй байгаа нь хуульд нийцэхгүй төсөвт өөрчлөлт оруулах, төсвийн тодотгол хийх эрсдлийг үүсгэж байна.
4. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2,630.0 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээ нь ямар хугацаанд хэрэгжих нь тодорхойгүй, суурь болон хүрэх түвшний үзүүлэлт, чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт тодорхой бус зэрэг төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.
5. Аймгийн 2025 оны төсвийн төсөлд зураг төсөл, төсөвгүй 6, зураг төсөл, төсөвтэй боловч магадлалын ерөнхий дүгнэлтгүй 17, магадлалын ерөнхий дүгнэлтийн хугацаа дууссан 4 төсөл, арга хэмжээг тусгасан нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна.
6. Сумын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй төсөл, арга хэмжээний саналыг авч жагсаалт гаргасан, ажлын хэсэг нь олон нийтэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн, урьдчилсан жагсаалтыг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн талаар материал байхгүй, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой 409.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан байна.
7. Аймгийн 2025 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэх тусгасан төсөл, арга хэмжээнээс Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдаагүй 8, аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй 18 төсөл арга хэмжээг тусгасан байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.1 дэх хэсэгтэй нийцэхгүй байна.
8. Төсвийн тухай хуулийн 29.2-д заасан Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргаагүй 6 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж, төсвийг батлах

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн үр дүнд суурилсан төсөвлөлтийг боловсруулах.
2. ҮХХ-ийн албан татвар 90.0 сая, АТБӨЯХ албан татвар 58.0 сая, газрын төлбөр 50.0 сая, сумын төсвөөс давсан орлогын 30 хувь болох 717.4 сая, ОНХС-ын эх үүсвэрт 110.0 сая, малын тоо толгойн албан татварыг тооцож төсөвт тусгах зэрэг нийт 1,025.4 сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэх
3. АИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг 105.0 сая, аймгийн Засаг даргын орон тооны зөвлөхийн цалин, НДШ-ийн зардлыг 63.6 сая, тогтмол зардлыг 153.4 сая, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг 215.0 сая, зураг төсөвгүй 6 төсөл арга хэмжээний 1,761.2 сая, нийт 2,298.2 сая төгрөгөөр зардлыг бууруулах
4. Эрсдэлийн сангийн зардлыг 257.1 сая, малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 500.0 сая, хүүхэд хамгааллын зардалд 50.0 сая, шүүхийн шийдвэр барагдуулах 52.4 сая, Бэрх хот тохижилтод олгох татаас 340.0 сая нийт 1,199.5 сая төгрөгийн зардлын үр ашгийг дээшлүүлэх
5. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2, 6.10.4-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.1, 7.2-т заасныг хэрэгжүүлэх
6. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга, хэмжээг техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулж, судалгаа шинжилгээ хийж, эрэмбэлэн, нэн тэргүүний ач холбогдлыг тодорхойлж, жагсаалт гарган, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг гаргаж орон нутгийн төсөвт тусгах;
7. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-д “орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” заалтад нийцүүлэн төсвийн төлөвлөлтийг боловсруулах.
8. Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүргийг тодорхойлж гэрээ байгуулан хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, хэрэгжилтийг тооцон ажиллах



Холбогдох байгууллагын санал:


Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал:


**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23000
Утас/Факс: (976) 7056 2151,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2024. 11. 29 № 9/2044
танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

"Аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх
аудит"-ын тайлантай танилцлаа.
Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, цаашид
зөрчлийг арилган ажиллах болно.


Д.АЮУРБУНЬ

231050743